

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажилладаг “7-694” брэндийн захирал Түвдэнтэй ярилцлаа



7-694 брэндийн үүсгэн байгуулагч, захирал Түвдэн

Хөнгөн хөгжмийн аялгуунд бүжих охид, хөвгүүд. Ноолууран ороолт, малгайг мэргэжлийн загвар өмсөгчдийн адил амилуулах цовоо сэргэлэн, хайр татам даунтай залуус...

“7-694” хувцас загварын брэнд нь 2020 оны 11-р сард буюу цар тахлын хүнд хэцүү цагт үүсгэн байгуулагдсан ч аль хэдийн шинэлэг өнгө төрхөөрөө олонд танигдаж чаджээ. “Өнөөдөр Цагаан Гурвалжин Өдөр” гэсэн дөрвөн үгийн үсгийн тоогоор “7-694” хэмээн брэндээ нэрлэсэн бөгөөд “Хязгааргүйд тэмүүлэх эрмэлзэл” гэсэн утгатай.

Үүсгэн байгуулагч Түвдэн нь маркетингийн мэргэжилтэй бөгөөд ажлын гараагаа ноос, ноолууран бүтээгдэхүүний тэргүүлэгч компани болох “Говь” ХК-аас эхлүүлж байсан. Тэрээр шинийг эрэлхийлэгч, бүтээлч сэтгэхүйдээ хөтлөгдөн маркетинг, брэнд хөгжүүлэлтийн салбарт шинэ өнгө төрх нэмэхээр залуучуудад чиглэсэн “7-694” брэндээ үүсгэн байгуулж, реклам сурталчилгаагаа зөвхөн цахим сүлжээгээр олон нийтэд түгээдэг. Хамтран үүсгэн байгуулагч, мэргэжлийн гэрэл зурагчин найз нь цахим сүлжээнээс дауны синдромтой хүүхэдтэй нэгэн ээжийн бичвэрийг олж уншсанаар “Монголын Дауны Холбоо”-той холбогдож, нарны хүүхдүүдийг анхны коллекцынхоо нүүр царай болгожээ. Сурталчилгааны зураг авалтаас гадна бүтээгдэхүүний шошго бүтээх гэх мэт ажлын захиалга өгч, эргэх холбоотой хамтран ажиллаж байна.

Мөн төрөлхийн арьс, үсний пигментын дутагдалтай буюу албинизмтай залуу, янз бүрийн бие галбиртай эмэгтэйчүүдийг шинэ коллекцуудынхаа нүүр царайгаар сонгож байжээ.

Анхны коллекцийн рекламанд тоглосон Бямбасүрэн “Ажил хийвэл ам тосдоно гэсэн үг бий. Найзуудынхаа хамтаар рекламанд тоглож, бусад ажилд нь тусалсандаа үнэхээр сэтгэл өндөр байна” хэмээн ярьж байлаа. Ээж Оюунчимэг нь “Нийгмийн хэвшмэл хандлагыг өөрчилж, бүх зүйлийг бидэнтэй адил хийж чаддаг гэдгийг харуулахыг зорьж буй Түвдэн захиралд чин сэтгэлээсээ талархаж байна” хэмээн инээмсэглэн суулаа.



Хөнгөн хөгжмийн аялгуунд бүжих охид, хөвгүүд (Зургийг 7-694 брэндийн фэйсбүүк хуудаснаас авав)

СЭДЭВ

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажилладаг “7-694” брэндийн захирал Түвдэнтэй ярилцлаа

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бие даах чадварт суралцахад дэмжлэг үзүүлэн ажилладаг “Энэрэл” МСҮТ

Түвдэн захирал “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бидэнтэй адил хувцас загвар, дуу хөгжимд дурлаж, нийгэмд идэвхтэй оролцохыг хүсдэг гэдгийг үеийнх нь залуучуудад ойлгуулах, өөрсдийн брэндээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжиж, ач холбогдол-боломжийн талаар олон нийтэд түгээх” чин хүсэл тээн ажиллаж байна.

Энэ нь DPUB 2 төслийн зорилго болох ажил хийх хүсэлтэй ХБИ, ААНБ-ууд дахь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны чиглэлтэй нийцэж байгаа нь талархууштай санагдаж байна. Байгальд ээлтэй, утга учир бүхий коллекцуудаараа дамжуулан нийгэмд эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх их үйлсэд нь улам өндөр амжилт хүсье.



Хөнгөн хөгжмийн аялгуунд бүжих Бямбасүрэн (Зургийг 7-694 брэндийн фэйсбүүк хуудаснаас авав)

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бие даах чадварт суралцахад дэмжлэг үзүүлэн ажилладаг “Энэрэл” МСҮТ



Зүүмэл урлалын ангийн оюутнуудтайгаа ярилцаж буй Уянга багш (Зүүн гар талаас 2 дахь нь)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээний нэг бол хүн бүрийн онцлогт тохирсон мэргэжлийн сургалтад хамруулж, ур чадвар эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх юм.

Өнгөрсөн оны 12-р сарын эхээр DPUB2 төслийн олон нийттэй харилцах ажилчид “Энэрэл” мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвөөр зочиллоо. Тус МСҮТ-ийг 2016 онд марафон гүйлтийн тамирчин Батдорж үүсгэн байгуулжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд модон эдлэл, тогооч, оёдол, гар урлал гэсэн үндсэн 4 мэргэжлээр 1 жилийн хугацаанд үнэ төлбөргүй суралцах боломжтой.

Одоогийн байдлаар нийт 53 хүн суралцаж байна. Өмнөх нийтлэлээр танилцуулж байсан “Дуня мебель” тавилгын дэлгүүрт мужаанаар ажилладаг Гандуулга тус сургуулийн төгсөгч билээ.


Захирал Батдорж сургуулиа байгуулах үед Уянга багшид хамтран ажиллах санал тавьсан бөгөөд тэр цагаас өдийг хүртэл хүний нөөц, нягтлан зэрэг бүхий л ажлыг нугалж, тун завгүй ажиллаж байна. Одоо тэрээр дэд захирлын үүрэг гүйцэтгэж байна. “Суралцагч нэг бүрийнхээ онцлогийг ойлгож, бие даан амьдрахад нь багахан ч гэсэн тус дэм болохыг хүсдэг” хэмээн ярих нь үнэхээр бахархууштай санагдлаа.

Сайны хажуугаар бэрхшээлүүд ч бий. Хувийн хэвшлийн байгууллагуудад төр, төрийн байгууллагатай хамтарч ажиллах боломж бага байдаг гэнэ. DPUB2 төсөл нь энэхүү асуудлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилладаг байгууллага, хувь хүмүүсийн талаар идэвхийлэн мэдээлэл цуглуулж, хоорондын сүлжээг бэхжүүлэн ажиллахыг зорьж байна.



Тогоочийн ангийн багш, сургуультай танилцахаар ирсэн зочид, DPUB2 төслийн ажилчид дурсгалын зураг даруулав.

 dpub.jica@gmail.com

 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160

 <https://www.facebook.com/jicadpub1and2>

 <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

